



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Улзын хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/4/СТА-ОНӨААТҮГ

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2020 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn Аудитор: Ж.Баяртуул Утас: 70584207 Цахим хаяг: Bayartuulj@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББ	Нягтлан бодох бүртгэл
ЗДТГ	Засаг даргын тамгын газар



Аудитын гэрчилгээ	3
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	10
4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	10
4.2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	10
4.3. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	11
4.4. Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлтийн тайлан	11



УЛЗЫН ХӨГЖИЛ ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Г.ЦООДОЛ ТАНАА

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.03.13 № 286

танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улзын хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Улзын хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон тодруулга тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улзын хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520204



Үүрэг, хариуцлага

Улзын хөгжил ОНӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандартуудтай нийцүүлэн түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ





2.1. Оршил

Улзын хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Г.Цоодол танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үйлчлүүлэгчийн санхүүгийн төлөвлөгөө батлуулж ажиллах талаарх зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улзын хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улзын хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 02-ноос 2020 оны 03 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Ж.Баяртуул хариуцаж хэрэгжүүлэв.

Улзын хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 08 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.



2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Улзын хөгжил ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Сумын иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг хангах” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Улзын хөгжил ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Албан байгууллага айл өрхийн хог ачилт болон цэвэрлэгээг тогтмол хийж, ахуйн үйлчилгээг хүргэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Улзын хөгжил ОНӨААТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорнод аймгийн Улзын хөгжил ОНӨААТҮГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд санхүүгийн программ хангамж ашиглаагүй байна.

Улзын хөгжил ОНӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Улзын хөгжил ОНӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 9 эрсдэлтэй асуудалд 9 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 462,659.3 мянган төгрөгөөс тооцон 9,253.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 1,560.9 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 онд зардлын гүйцэтгэл буурсантай холбоотой болно.



2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Улзын хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23,940.1 мянган төгрөгөөр буюу 11.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан ашиг дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,631.2	2,002.3	-628.9
Үндсэн хөрөнгө	319,033.2	339,775.5	20,742.3
Элэгдэл	-78,305.3	-40,965.9	37,339.4
Нийт хөрөнгө	397,338.5	382,743.7	-14,594.8
Өр төлбөр	322.9	322.9	0.0
Хуримтлагдсан ашиг	340,786.6	340,786.6	0.0
Тайлант үеийн үр дүн	0.0	-14,594.8	-14,594.8
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	56,229.0	56,229.0	0.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	397,338.5	382,743.7	-14,594.8

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь төсвийн хөрөнгө оруулалтаар болон ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хөрөнгө орлогод авсантай холбоотой байна.

Хуримтлагдсан ашиг дансны үлдэгдэл 340,786.6 мянган төгрөг болж -14,594.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Тайлант онд Улзын хөгжил ОНӨААТҮГ нь нийт 25,524.8 мянган төгрөгийн орлоготой ажиллажээ. Үүнээс ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар 7,200.0 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч, хог цэвэрлэгээ, халуун усны орлого 18,324.8 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, ажиллагсдын цалин болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 10,361.9 мянган төгрөг, хог машины тээвэр шатахууны зардалд 6,428.7 мянган төгрөг, тээврийн автомашин болон бусад ахуйн үйлчилгээний төсвийн засвар үйлчилгээ болон гэрэл цахилгааны заралд 9,363.1 мянган төгрөгийг зарцуулж, 628.9 мянган төгрөгийн алдагдалтай ажиллажээ.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 9 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 9 эрсдэл тодорхойлж нийт 9 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар санхүүгийн төлөвлөгөө батлуулж ажиллаагүй зөрчилд 2 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Санхүүгийн төлөвлөгөө батлуулж ажиллахад анхаарах.



2.13. Шилэн дансны мэдээлэл

Улзын хөгжил ОНӨААТҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллага нь Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллээ бүрэн байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгөгдөж 100 хувь биелүүлсэн байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Улзын хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Улзын хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Санхүүгийн төлөвлөгөөний талаар

1.1. Илрүүлэлт: Тайлант онд Улзын хөгжил ОНӨААТҮГ нь үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөө батлуулж ажиллаагүй байна.

1.2. Эрсдэл: Байгууллагын тасралтгүй үйл ажиллагаа алдагдах. Хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах.

1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16.5.2 дахь “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэсэн заалтыг мөрдөн ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах болно.

2. Дотоод хяналтын талаар

2.1. Илрүүлэлт: Хог хураамжийн орлогыг 2-3 хоногийн дараа харилцах дансанд тушаадаг.

2.2. Эрсдэл: Ашиглан үүсэх магадлалтай.

2.3. Өгсөн зөвлөмж: Энэ нь үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн Сайдын 2012 оны 12 сарын 21-ний өдрийн 276 дугаар "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 7.2 дэх "Мөнгөн кассын нярав бэлэн мөнгөний гүйлгээ тус бүрийг кассын дэвтэрт бүртгэж, өдөр бүр кассын тайлан гаргаж кассын дэвтрийн хуудас бүрийг дугаарлан дэвтрийн сүүлчийн хуудасны тоог бичиж дараагийн ажлын өдрийн 12 цагаас хэтрүүлэхгүйгээр нягтлан бодогчид шилжүүлэн өгч хянуулж байна" заалтыг мөрдөн ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2 631 223,09	2 002 277,01
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2 631 223,09	2 002 277,01
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	2 631 223,09	2 002 277,01
3121	Төгрөг	2 631 223,09	2 002 277,01
31213	Арилжааны банк дахь харилцах	2 631 223,09	2 002 277,01
2	ЭРГЭЛТИЙН БҮС ХӨРӨНГИЙН ДҮН	394 707 334,12	366 102 060,72
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	394 707 334,12	366 102 060,72
392	Биет хөрөнгө	394 707 334,12	366 102 060,72
39201	Барилга, байгууламж, орон сууц	249 181 280,00	249 181 280,00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(5 679 522,46)	(35 283 500,56)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	20 000 000,00	42 000 000,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(11 428 571,50)	(13 428 571,50)
39214	Бусад үндсэн хөрөнгө	211 033 053,00	216 033 053,00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(68 398 904,92)	(92 400 200,22)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	397 338 557,21	368 104 337,73
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	322 958,58	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	322 958,58	-
413	Өглөг	322 958,58	-
4136	Бусад өглөг	322 958,58	-
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	55 192,52	-
41365	Цалингийн өглөг	7 766,06	-
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	260 000,00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	397 015 598,63	368 104 337,73
51	Засгийн газрын хувь оролцоо	397 015 598,63	368 104 337,73
512	Хуримтлагдсан үр дүн	397 015 598,63	368 104 337,73
51210	Өмнөх үеийн үр дүн	340 786 583,15	340 786 583,15
51220	Тайлант үеийн үр дүн	-	(28 911 260,90)
51230	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	56 229 015,48	56 229 015,48
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	397 338 557,21	368 104 337,73

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	462 659 311,05	78 049 582,00
12	ТАТВАРЫН БҮС ОРЛОГО	462 659 311,05	78 049 582,00
120	Нийтлэг татварын бүс орлого	51 049 582,00	51 049 582,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	51 049 582,00	51 049 582,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	51 049 582,00	51 049 582,00
121	Хөрөнгийн орлого	411 609 729,05	27 000 000,00
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	411 609 729,05	27 000 000,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	61 461 120,32	106 960 842,90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	61 461 120,32	106 960 842,90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	61 461 120,32	106 960 842,90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7 291 817,94	8 923 231,00
210101	Үндсэн цалин	7 291 817,94	8 923 231,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	752 640,00	2 275 930,08
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	752 640,00	2 275 930,08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	200 000,00	-
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	200 000,00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	13 575 825,00	10 802 110,00
210401	Бичиг хэрэг	55 000,00	-
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	12 351 000,00	5 905 610,00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	1 169 825,00	4 896 500,00
2107	Томилдолт, зочны зардал	-	360 200,00
210702	Дотоод албан томилдолт	-	360 200,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39 640 837,38	26 153 737,08
210813	Бусад зардал /ТӨҮГ/	39 640 837,38	26 153 737,08
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	58 445 634,74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	140 361,34
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хөргөдөл	-	58 305 273,40
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	401 198 190,73	(28 911 260,90)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮС ОРЛОГЫН ДҮН	418 909 729,52	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	418 909 729,52	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮС ЗАРДЛЫН ДҮН	56 229 015,48	-
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	56 229 015,48	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮС ҮР ДҮН (4)=(145-225)	362 680 714,04	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	763 878 904,77	(28 911 260,90)



4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	55 701 098,20	50 421 082,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	55 701 098,20	50 421 082,00
120	Нийтлэг татварын бус орлого	55 701 098,20	50 421 082,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	27 850 549,10	50 421 082,00
120005	Түрээсийн орлого		628 500,00
120009	Бусад орлого	7 300 000,00	24 896 291,00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	20 550 549,10	24 896 291,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	54 764 944,86	51 050 028,08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	54 764 944,86	51 050 028,08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	54 764 944,86	51 050 028,08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7 291 817,94	8 923 231,00
210101	Үндсэн цалин	7 291 817,94	8 923 231,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	752 640,00	2 275 930,08
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	752 640,00	2 275 930,08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	200 000,00	-
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	200 000,00	
2104	Хангамж, бараа материалын зардал	13 520 825,00	10 802 110,00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	12 351 000,00	5 905 610,00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	1 169 825,00	4 896 500,00
2107	Томилолт, зочны зардал	-	360 200,00
210702	Дотоод албан томилолт		360 200,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5 149 112,82	1 905 873,84
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	5 149 112,82	1 905 873,84
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27 850 549,10	26 782 683,16
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27 850 549,10	26 782 683,16
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	936 153,34	(628 946,08)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	936 153,34	(628 946,08)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1 695 069,75	2 631 223,09
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2 631 223,09	2 002 277,01

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0,00	56 229 015,48	397 015 598,63	0,00	453 244 614,11
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0,00	56 229 015,48	397 015 598,63	0,00	453 244 614,11
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0,00	340 786 583,15	340 786 583,15	0,00	681 573 166,30
D01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл		397 015 598,63	397 015 598,63	0,00	397 015 598,63
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0,00	340 786 583,15	340 786 583,15	0,00	681 573 166,30
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0,00	56 229 015,48	56 229 015,48	0,00	112 458 030,96
D08	Тайлант үеийн үр дүн	0,00	0,00	-28 911 260,90	0,00	-28 911 260,90
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0,00	397 015 598,63	368 104 337,73	0,00	368 104 337,00

